Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, бэрхшээл

Аудитын нэр: "Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2015 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээниий хэрэгжилт, үр дүн"

Аудитын код: ҮАГ-ГАГ/2016/01-ГА

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх: Аудитыг УИХ-ын Төсвийн Байнгын хорооны 2016 оны 1 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2016 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын төрөлжсөн болон орон нутаг дахь салбар байгууллагын бүрэн эрхийн хүрээнд аудитыг хийв.

Аудитын зорилт: Хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилтэд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгднэ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийв. Үүнд:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалт:
   - Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт үндэслэлтэй, оновчтой төлөвлөсөн үү?
   - Хөрөнгө оруулалтын төсөл арга, хэмжээний худалдан авах ажиллагааг хуулийн дагуу үр дүнтэй байна уу?
   - Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй байна уу?

2. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт:
   - Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт үндэслэлтэй, оновчтой төлөвлөсөн үү?
   - Хөрөнгө оруулалтын төсөл арга, хэмжээний худалдан авах ажиллагааг хуулийн дагуу үр дүнтэй байна уу?
   - Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй байна уу?
3. Төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр Хөгжлийн банкнаас 2015 онд санхүүжсэн төсөл, арга хэмжээний үр дүн

Аудитын хамарсан хүрээ: Аудитаар улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2015 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг Говь-Алтай аймгийн төсвийн өрөнхийлөн захирагч, аймгийн санхүү төрийн сангийн хэлтэс, хөгжлийн бодлогын хэлтэс, ГХБХБГазар, Худалдан авах ажиллагааны алба болон холбогдох гүйцэтгэгч болон захиалагч байгууллагуудын хүрээнд шалгав.

Үндсэн мэдээлэл:

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын талаар:

- Тайланд онд 27 хөрөнгө оруулалтын ажлыг 2,991.2 сая төгрөгөөр санхүүжүүлсэн байна. Дээрх ажлуудын 14 ажил нь тайланд онд шинээр хийгдсэн ажил бөгөөд, 7 ажил нь өмнөх оноос шилжин ирсэн, 6 ажил нь хугацаа хойшлогдсон хөрөнгө оруулалтын ажлууд байна.
- Аймгийн ИТХ-аар батлагдаагүй 154.7 мянган төгрөгийн ажлыг санхүүжүүлсэн байна.
- Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн ажлуудын Аймгийн засаг даргын Бидний-Алтай хөтөлбөр, Аймгийн үндсэн чиглэлд 84.2 хувийг тусгасан байна.
- Аудитын зөвлөмжийн дагуу ХАА-ны үйл ажиллагаа сайжирсан өмнөх оны зөрчлийг давтан гаргаагүй байна. Мөн 2015 онд байгуулсан гэрээнүүдэд гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг бүрэн тусгасан байна.
- Шилэн дансанд байршуулах мэдээллээ 2015 онд 5.3 сая төгрөгөөр дутуу оруулсан байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар:

- Тайланд онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Говь-Алтай аймагт 19 ажил хэрэгжиж байгаагаас 6 ажлын эрх шилжин ирсэн байна. Дээрхи ажлуудад гэрээний дагуу 1,646.3 сая төгрөгийн санхүүжилт олгохоос 1,121.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгож 525.3 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосон байна.
- Худалдан авах ажиллагааны албанд 5 ажилд тендер шалгаруулж төсөвт өртгөөс 117.1 сая төгрөгийн тендерийн хэмнэлт гарсан байна.
- Шилжин ирсэн хөрөнгө оруулалтын ажлаас 1 ажил буюу Есөнбулаг сумын 2 дугаар сургуулийн их засварын ажил бүрэн хэрэгжиж дуусан бөгөөд бусад ажлын тухайд 30-80 хувийн гүйцэтгэлтэй явж байна гэсэн тайлбарыг ирүүллээ.
- Улсын төсвөөр хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтын ажлууд нь аймаг орон нутгийн хэрэгцээ шаардлагад нийцэж байгаа хэдий ч түүний ажлын явц хэтэрхий удааширалтай байна.

Эрсдэлийн үнэлгээ: Урьдчилсан судалгааны явцад хийсэн дүн шинжилгээ, харилцан ярилцлагад үндэслэн ерөнхий эрсдэлийг "дунд' гэж үнэлэв.

Аудитын арга зүй: Аудитыг хийхдээ гүйцэтгэлийн аудитын гарын авлагад дурьдсан арга зүйг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, санал асуулга авах, лавлагаа авах, зарцуулалтын баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ, харьцуулалт хийх, газар дээрх нөхцөл байдалтай танилцаж фотожуулах үнэлэлт дүгнэлт өгөх зэрэг арга зүйг ашиглаж аудитын хөтөлбөр горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүгнэлт, холбогдох шийдвэрийн санал боловсруулаа.

2015 онд шинээр эхэлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд хувийн хэргийг шинээр бүрдүүлэх бөгөөд өмнөх оноос дамжин ирсэн объектын хувьд хувийн хэрэгт нэмэлт өөрчлөлтийг хийв.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд: Аудитад дараах хууль. эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглана

- Монгол Улсын 2008-2015 оны төсвийн тухай хууль болон түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт
- Төсвийн тухай хууль
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгэз, худалдан авах тухай хууль
- Барилгын тухай хууль
- Концессын тухай хууль
- Дээрх хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан УИХ, Засгийн газрын тогтоол, бусад эрхийн актууд
- Төсвийн хүрээний мэдэгдэл,
- Засгийн газрын 2015 оны 377 дугаар тогтоол
- Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын журам
- Сангийн сайдын 2012 оны 264 дүгээр тушаалаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн акт стандарт

Аудитын хугацаа: Аудитыг 2015 оны 04 дүгээр сарын 06-нд эхэлж, тайпанг 2016 оны 4 дүгээр сарын 20-нд дуусгаж, удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн, ҮАГ-т хүргүүлэв.

Аудит хийсэн бүрэлдэхүүн: Аудитыг Аймгийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Түвшинбаяр удирдаж, аудитын менежер Д.Эрдэнэчимэг үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж шинжээч Э.Сүнжидмаа, Х.Билэгбаяр нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэв.

I Бүлэг. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүн

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл хангалтгүй байна.

А. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг үндэслэлтэй төлөвлөжээ.

Монгол Улсын 2015 оны Төсвийн тухай хуульд Говь-Алтай аймагт 49,219.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 19 төсөл арга хэмжээг баталсан байна.

Төсвийн тухай хуульд тусгагдан хэрэгжиж байгаа 19 төсөл, арга хэмжээний 6 ажил аймагт эрх шилжиж ирсэн, 13 ажлын эрх шилжиж ирээгүй байна.

Аудитаар төсөл арга хэмжээнүүдийн үндэслэлтэй төлөвлөсөн эсэхийг судалж үзэхэд 14 төсөл арга хэмжээ нь аймгийн хөгжлийн цогц бодлого, үндсэн чиглэл, орон нутагт хэрэгжүүлэх тэргүүлэх ач холбогдол бүхий ажлын жагсаалтад орсон байна. /Хавсралт№1/

Аймагт эрх шилжин ирсэн 5 барилгын ажлыг үзэхэд Төсвийн тухай хууль, Барилгын тухай хуульд заасны дагуу зураг төсөв боловсруулагдсан төсөл арга хэмжээг төсөвт тусган хэрэгжүүлсэн байна.

Б. Хөрөнгө оруулалт төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа хуулийн дагуу зохион байгуулсан байна.

Аймгийн худалдан авах ажиллагаанд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2015 онд сайдын багцаас эрх шилжиж ирсэн 6 ажлаас 5 ажлыг орон нутгийн худалдан авах ажиллагаа зарлагдаж нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулж шууд гэрээ байгуулсан байна. Эдгээр төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг цахим болон цаасан хэлбэрээр зохион байгуулжээ. Тайшир сумын Соёлын төвийн барилгын дутуу хөрөнгө шийдвэрлэгдсэн тул худалдан авах ажиллагаа зарлаагүй байна.

Аймгийн худалдан авах ажиллагааны алба Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 5,090.0 сая төгрөгийн өртөгтэй 5 ажилд тендер шалгаруулж 4,972.9 сая төгрөгөөр гэрээ байгуулан 117.1 сая төгрөгийн төсвийн хэмнэлт гаргаж ажилласан байна.

Аймгийн Худалдан авах ажиллагааны алба нь Улсын төсвийн хөрөнгө оруулалт болон бусад төсөл арга хэмжээний санхүүжилтээр хийгдэх ажлуудад тендер шалгаруулалтыг хийхдээ тендерийн урилгыг өдөр тутмын Зууны мэдээ сонинд нийтлүүлдэг мөн WWW.e-procurement.mof.gov.mn, www.govi-altai.gov.mn, www.meps.gov.mn вэб сайтуудад тендерийн урилга болон баримт бичгүүдийг нийтэлж ажилласан байна.

В. Хөрөнгө оруулалт төсөл, арга хэмжээний гэрээний хэрэгжилт хангалтгүй

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2015 онд эрх шилжиж ирсэн 6 ажлыг 6,060.1 сая төгрөгийн төсөвт өртөгөөр гүйцэтгэхээр гэрээ байгуулласан бөгөөд 5 ажлын хугацаа болоогүй байна.

Соёл амралтын хүрээлэн байгуулах ажлыг 1,965.7 сая төгрөгөөр гүйцэтгэхээр 5 багцад хуваан гэрээ байгуулсан бөгөөд дээрх 5 багцын ажлуудаас "Жи ти кей эс" ХХК нь 286.6 сая төгрөгийн өртөгтэй 2-р багцын ажлыг гэрээт хугацаанд гүйцэтгэн хүлээлгэн өгсөн байна.

Үлдсэн 4 багцын тухайд: Гэрээт хугацаандаа ажлаа гүйцэтгээгүй бөгөөд 2015 оны 07 дугаар сарын 29-ний өдөр хүртэл гэрээг сунгасан байна. /Хавсралт№ 2/

Энэ нь 2015 онд батлагдсан Улсын төсвөөс санхүүжилтийг бүрэн ирүүлээгүйгээс гэрээг сунгах үндэслэл болсон байна.

Аудитаар гэрээнд тусгагдсан тусгай нөхцөлүүдийг тулгаж барилга байгууламжийн гүйцэтгэлд газар дээр нь очиж дүн шинжилгээ хийж зурагжууллаа. Үүнд:

Алтай сумын сургуулийн барилгын өргөтгөлийн ажлын гэрээг Аймгийн ЗД-ын 2015/06/09-ний өдрийн захирамжийг үндэслэн гэрээнд тусгагдах тусгай нөхцлийн дагуу ажлыг 2015/06/16 эхлэн 2016/08/28-ний хооронд хийж дуусгахаар 1,350.1 сая төгрөгөөр гэрээг байгуулсан байна. Барилгын ажлын гүйцэтгэгч "Аксу-Алтай" ХХК ба газар дээр нь очиж зураг авалт хийж үзэхэд хундамны цутгалт бүрэн хийгдэж дуусан. Гүйцэтгэгч компани гаргаж өгсөн 220.0 сая төгрөгийн буюу 16 хувийн гүйцэтгэлтэй байна.

Цогт сумын Баянтоорой тосгоны дотуур байр барилгын ажлын гэрээг Аймгийн ЗД-ын 2015/08/24-ний өдрийн захирамжийг үндэслэн гэрээнд тусгагдах тусгай нөхцлийн дагуу ажлыг 2015/09/01-ээс эхлэн 2016/09/01-ний хооронд хийж дуусгахаар 990.0 сая төгрөгөөр гэрээг байгуулсан байна.

Барилгын ажлын гүйцэтгэгч нь "Аз өрнөх" ХХК ба газар дээр нь очиж бодит байдалтай танилцахад барилгын ажлын өрлөгийн ажил хийгдсэн ба цонх, болон дотор гадна шавардлага хийгээгүй байна. Тухайн гүйцэтгэгч компани 2015 оны 12 сарын 31-ээр байдлаар гаргаж ирсэн гүйцэтгэл 292.8 сая төгрөгийн буюу 30 хувьтай байна.

Есөнбулаг сумын 2 дугаар сургуулийн барилгын их засварын ажлын гэрээг Аймгийн ЗД-ын 2015/05/05-ний өдрийн захирамжийг үндэслэн гэрээнд тусгагдах тусгай нөхцлийн дагуу ажлыг 2015/05/12-ээс эхлэн 2015/08/15-ний хооронд хийж дуусгахаар 135.4 сая төгрөгөөр гэрээг байгуулсан байна.

Барилгын ажлын гүйцэтгэгч нь "Шатат" ХХК ба гүйцэтгэлийг бодит байдал дээр очиж үзэхэд их засварын ажил бүрэн хийгдсэн цонхыг сольж ажлыг улсын комисс хүлээн авсан байлаа.

Тайшир сумын Цэцэрлэгийн барилгын ажлын гэрээг Аймгийн ЗД-ын 2015/06/02-ний өдрийн захирамжийг үндэслэн гэрээнд тусгагдах тусгай нөхцлийн дагуу ажлыг 2015/06/20-оос эхлэн 2016/06/20-ний хооронд хийж дуусгахаар 531.6 сая төгрөгөөр гэрээг байгуулсан байна.

Барилгын ажлын гүйцэтгэгч нь "Шатат" ХХК ба бодит байдал дээр нь очиж үзэхэд ханын өрлөгийг хийсэн ба 2 давхарын өрлөг өрөөгүй, шаавардлага хийгдээгүй байлаа. 2015 оны 12 сарын 31-ний байдлаар гүйцэтгэгч компаний гаргаж өгсөн гүйцэтгэлээр 275.0 сая төгрөгийн буюу 50 хувийн гүйцэтгэлтэй байна.

Тайшир сумын соёлын төвийн барилгын ажлын гэрээг 2011/10/17-наас эхлэн 2016/11/01-нд дуусгахаар нэмэлт гэрээг 1,087.0 сая төгрөгөөр хийсэн байна.

Барилгын ажлыг гүйцэтгэгч "Хонгор буурал" ХХК ба бодит байдал дээр нь очиж үзэхэд барилгын хана болон дээвэр ажил бүрэн дуусан, гадна, дотно шавардлага, сантехникийн ажил хийгдээгүй байна. 2015-2016 онуудад гүйцэтгэгч компаний гаргаж өгсөн гүйцэтгэлээр 718.7 сая төгрөгийн буюу 60 хувийн гүйцэтгэлтэй карказ босгосон өрлөг дуусан дотор засал хийгдсэн. Мөн барилгыг 2011 онд Төсвийн хуулиар батлахдаа 350.0 сая төгрөгөөр батласан бөгөөд 2015 оны төсөвт өртгийг батлахдаа 1087.4 сая төгрөгөөр буюу 737.4 сая төгрөгөөр нэмж баталсан байна.

Санхүүжилтийг барилга хөгжлийн төвөөс олгосон тул санхүүжилтийн тулгалт хийгээгүй болно.

Соёл амралтын хүрээлэн байгуулах ажлын хүрээнд 5 багц ажлыг нийт 1,966.1 сая төгрөгөөр хийж гүйцэтгэх гэрээ байгуулсан байна. Тус 5 багцыг задалвал дараах байдалтай байна.

Хүснэгт1.1

Д/Д	Төсөл арга хэмжээний нэр	Гүйцэтгэгч	төсөвт өртөг	санхүүжүүлсэн дүн	дутуу санхүүжилт		нэмэлт гэрээ	ажлын гүйцэтгэл
1	Соёл амралтын хүрээлэнгийн гадна хашаа, хаалга хийх ажил	""Алтайн-Өргөө" ХХК	335.7	150.0	185.7	2015.08.06 - 2015.11.12	2015.11.10-2016.05.30	80%
2	Соёл амралтын хүрээлэнгийн барилгын ажил	"Жи ти кей эс "ХХК	286.6	140.0	146.6	2015.07.29 - 2015.10.01		100%
3	Соёл амралтын хүрээлэнгийн гУсан оргилуур, усан хангамжийн ажил	"Ус-Алтай" ХХК	176.0	100.0	76.0	2015.07.30 - 2015.11.10	2015.11.10. -2016.05.30	40%
4	Соёл амралтын хүрээлэнгийн тоглоомийн талбай байгуулах	"Ус-Алтай" ХХК/	100.4	76.0	24.4	2015.07.30 - 2015.11.10	2015.11.10-2016.05.30	50%
5	Соёл амралтын хүрээлэнгийн цахилгаан дамжуулах шугам, дэд өртөө байгуулах	"Халиун акарга" ХХК	68.4	34.0	34.4	2015.07.29 - 2015.11.10	2015.11.10-2016.05.30	70%
	Дүн		967.1	500.0	467.1	-	-	

Дээрхи хүснэгтээс харахад 467.1 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу өгсөн, ажлын гүйцэтгэл дунджаар 60 хувьтай байна.

Соёл амралтын хүрээлэнгийн 1 дүгээр багцын тухайд Хүснэгт 2

№	Хийсэн ажил	Зураг төсвөөр хийх талбайн хэмжээ метр	Гүйцэтгэл метр	Дутуу	Тайлбар
1	Суурь, хайс	1640.0	1580.9	59.1	Тус хашааны ажлыг хийх явцад нисэх буудлын зурвас газарт орсон тул хашааг татаж наашлуулсантай холбоотой санхүүжилтийг буцаан татах тооцоо гарч байна.
2	Санхүүжих гэрээ гүйцэтгэл:	335,753.50	323,654.40	12,099.10	
3	Үүнээс: хяналтын зардал	5785.1	5576.6	208.5	
Үлдэгдэл санхүүжилтаас суутган тооцох дүн		0	0	**11,890.60**	

Соёл амралтын хүрээлэнгийн 1-р багцын ажлыг "Алтайн Өргөө" ХХК зураг төсөв гэрээний дагуу анх 1640 метр талбайд хашаалахаар байсан хэдий ч аудитаар гүйцэтгэлийг тооцон үзэхэд ажлын тоо хэмжээнээс 59.1 метр дутуу буюу 1580.9 метр талбайн ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх шилжиж ирсэн 6 ажлаас Тайшир сумын Соёлын төвийн барилгын ажил нь Барилгын хөгжлийн төвөөс санхүүжилтаа авсан тул гүйцэтгэлийг аудитаар тулгаагүй болно. Харин аймгийн төрийн сангаар санхүүжилт нь дамжсан 5 ажлын гүйцэтгэлийн хуулгыг боловсруулан тулгалт хийсэн.

Аудитаар 2015 онд хөрөнгө оруулалтын 6 ажилд гэрээний дагуу 1,646.3 сая төгрөгийн санхүүжилт олгох ёстойгоос тус онд 1,121.0 сая төгрөгийн санхүүжилтийг олгож 525.3 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосон байна. /Хавсралт№3 /

Эрх шилжиж ирсэн төсөл арга хэмжээний 6 ажлаас хуулийн хугацаандаа бүрэн дуусан улсын комисс хүлээн авсан 1 ажил байгаа ба бусад ажлууд нь дуусаагүй байна.

Есөнбулаг сумын 2 дугаар сургуулийн барилгын их засварын ажлыг 2015 оны 08 сарын 10 өдөр 7 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтанд оруулах комисс ажиллаж 73 ширхэг цонх, халаалтын гол түгээх шугамын сувагт угсралтийн ажил болон техникийн зураг төсвийн дагуу бүрэн хийгдсэн эсэхэд дүгнэлт өгч ашиглалтанд оруулах нь зүйтэй гэж актыг үйлдсэн байна.

Мөн Соёл амралтын хүрээлэн байгуулах 5 багц ажлаас "Жи ти кей эс" ХХК-ний гүйцэтгэсэн 2 дахь багцын ажлыг улсын комисс хүлээн авч акт үйлдсэн ба комисс дараах хийсэн ажлыг хүлээн авсан байна. Үүнд: харуулын байр 2ш, суудрэвч 11ш, хөлбөмөгийн

талбайн хашаа 4 тал, хүүхдийн саран хэлбэртэй саравч 7ш, худалдааны цэг 3ш, касс түгээх байр 1 ширхэгийг хийж байгуулсан мөн 60 хүний суудалтай сандлаас 34 сандлыг суулгаж цаг агаар дулаарахад 26 сандал хийхээр тохиролцсон байна.

Эрх шилжиж ирсэн төсөл арга хэмжээний 6 ажилд захиалагчийн хяналтыг ГХБХБГ хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тус онд дээрх ажлуудад үе шатны хяналтыг тухай бүр тавьж журналд бүртгэж баримтжуулан акт үйлдсэн ба хяналтыг давхардсан тоогоор 3-4 удаа хийсэн байна.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2015 онд хийгдэж дуусан ашиглалтанд орж улсын комисс хүлээн авсан доорх ажлуудад ГХБХБГ нь 2-3 удаа хяналт хийсэн боловч хяналтын зардлыг шилжүүлээгүй байна.

Тухайлбал: Есөнбулаг сумын 2 дугаар сургуулийн их засвар хяналтын зардал 2.4 сая төгрөг, соёл амралтын хүрээлэн байгуулах 5 багц ажлаас "Жи ти кей өс" ХХК-ний гүйцэтгэсэн 2 дахь багц ажлын хяналтын зардал 4.9 сая төгрөг нийт 7.3 сая төгрөгийн хяналтын зардлыг олгоогүй байна.

Дээрх ажлуудыг улсын комисс хүлээн авсан ба ашиглагч байгууллага төсөвт өртгийн дагуу НББ-д бүрэн тусгаж ажилласан байна.

Эрх шилжиж ирээгүй хөрөнгө оруулалтын талаар:

Аймгийн хэмжээнд 2008-2015 оны Төсвийн тухай хуульд батлагдсан боловч дуусгаж хүлээлгэн өгөөгүй хөрөнгө оруулалтын 11 ажил байна. Эдгээр ажлууд нь он дамнаж одоог хүртэл ашиглалтанд ороогүй байгаа нь санхүүжилтийг хугацаандаа олгоогүйтэй холбоотой байна.

Төсвийн тухай хуулийн дагуу анх баталсан төсөвт өртгийг энэ оны Төсвийн тухай хуулиар баталсан төсөвт өртгүүдтэй тулгаж үзлээ.

Төсвийг анх 36,050.8 сая төгрөгөөр батласан бөгөөд тодотголоор 38,981.3 сая буюу төсөвт өртгийг 2,930.5 сая төгрөгийг нэмж тодотгожээ.

Тухайлбал:

- Баян-Уул сургуулийн барилгын төсөвт өртөгийн 1,981.6 сая төгрөгөөр нэмж баталсан хэдий боловч ашиглалтанд оруулаагүй байна.
- Төрөх эмнэлэгийн 50 ортой барилгын төсөвт өртгийг 948.9 сая төгрөгөөр нэмж баталсан байна. Энэ зөрчил нь анх төсөвт өртгийг баталдаггүй, зөвхөн санхүүжүүлэх хэлбэрээр төсвийг батлаж байгаатай холбоотойгоор үүссэн байна.

Эдгээр хөрөнгө оруулалтыг зурагаар харуулвал:





Баян-Уул сургуулийн гүйцэтгэл Төрөх эмнэлэг 50 ортой Тайшир сумын цэцэрлэг




Тайшир сумын Соёлын төв Хүүхдийн ордон Аврах гал унтраах анги

Төсвийн тухай хуулиар батлагдсан боловч аймагт огт хийгдээгүй 2 ажил байна.

- Хот суурин захиргаа, сав гарын захиргаа байгуулах 1,500.0 сая төгрөгийн өртөг бүхий ажил, Аймаг сум суурин нутаг дэвсгэрт газрын хөдлөлийн бичил мужлалын зураглал хийх, газар хөдлөлийн эрсдэл тодорхойлох, инженер, геологи, геодро геологи тенхникийн судалгааны ажил 3,000.0 сая төгрөгийн өртөгтэй ажлууд нь огт хийгдээгүй байна. /Хавсралт №4 /

Зөрчигдсөн хуулийн заалт:
2008 оны төсвийн тухай хууль,2009 оны төсвийн тухай хууль, 2010 оны төсвийн тухай хууль, 2011 оны төсвийн тухай хууль, 2012 оны төсвийн тухай хууль, 2013 оны төсвийн тухай хууль , 2014 оны төсвийн тухай хууль, 2015 оны Төсвийн тухай хууль

Илрүүлэлт:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2014-2015 онуудад гэрээт хугацаандаа ажлаа хийж дуусгаагүй байгаа Соёл амралтын хүрээлэн байгуулах ажлын гүйцэтгэл хангалтгүй байна. Тухайлбал: "Ус-Алтай ХХК" нь 1,275.2 сая төгрөгийн ажил хийхээс 2015 оны 12 сарын 31-ний байдлаар 804.6 сая төгрөгийн санхүүжилт авч 470.6 сая төгрөгийн санхүүжилт дутуу, гүйцэтгэл 57 хувьтай, "Алтайн өргөө" ХХК 335.7 сая төгрөгийн ажил хийхээс 150.0 сая төгрөгийн санхүүжилт авч, 185.7 сая төгрөгийн санхүүжилт дутуу гүйцэтгэл 80 хувьтай, "Халиун-Азрага" ХХК 68.4 сая төгрөгийн ажил хийхээс 34.0 сая төгрөгийн санхүүжилт авч, 34.4 сая төгрөгийн санхүүжилт дутуу гүйцэтгэл 70 хувьтай одоогоор ажил нь эхлээгүй байна.

2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2015 онд хийж дуусан ажлуудын хяналтын зардал 7.3 сая төгрөгийг хяналт тавьж ажилласан байгууллага аж ахуй нэгжүүдэд олгоогүй байна.

3. Соёл амралтын хүрээлэнгийн 1-р багцын ажлыг "Алтайн Өргөө" ХХК зураг төсвийн дагуу 1640 метр 1640 метр талбайд хашаалахаар байсан хэдий ч аудитаар гүйцэтгэлийг тооцон үзэхэд ажлын тоо хэмжээнээс 59.1 метр дутуу буюу 1580.9 метр талбайн ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

II Бүлэг. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, үр дүн

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт нь аймгийн хэрэгцээ шаардлагад нийцсэн ажлууд хийгджээ.

А. Хөрөнгө оруулалтын төсөл,арга хэмжээний төлөвлөлт үндэслэлтэй төлөвлөсөн байна.

Аймгийн ИТХ-ын 2014 оны 12 сарын 25-ны өдрийн 08/06 тоот тогтоолоор орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2015 онд анх 105.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөж, ИТХ-ын 2015 оны 12 сарын 04-ний өдрийн 12 дугаар тогтоолоор 2,941.2 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг буюу анх батлагдсан төсөл арга хэмжээг 2,836.0 мянган төгрөгөөр нэмж баталжээ. Аймгийн ИТХ-аар ОНТХО-ыг 2 удаа тодотгосон байна.

Дээрхи батлагдсан ажлуудын 84.2 хувь нь аймгийн үндсэн чиглэл болон аймгийн Засаг даргын "Бидний-Алтай" мөрийн хөтөлбөрт багтсан байна. Хөрөнгө оруулалтын ажлууд нь аймгийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, аймаг орон нутгаас авч хэрэгжүүлж байгаа бодлоготой уялдсан ажлууд болжээ. /Хавсралт№ 5/

Б. Хөрөнгө оруулалт төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа хуулийн дагуу зохион байгуулсан байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалтаар 2015 онд нийт 27 ажилд ажил хийснээс өмнөх оны 7 ажил, Засгийн газрын 68 дугаар тогтоолын босго үнээс доош 2 ажилд шууд гэрээ байгууллан 16 ажилд тендер зарлаж шалгаруулсан байна.

Аймгийн худалдан авах ажиллагааны алба бэлтгэл ажлыг хийхдээ захиалагчаас техникийн тодорхойлолт буюу ажлын зураг, зураг төслийн даалгавар, техникийн нөхцөл, газрын захирамж, геологийн дүгнэлт холбогдох үндэслэх эх материалуудыг бүрдүүлсний дараа үнэлгээний хороог байгуулан үнэлгээний хороонд А3 гэрчилгээтэй гишүүд ажилласан байна.



Аудитаар тендерт оролцогчдын материалыг тендерийн баримт бичигт тусгасан эсэхийг шалгаж шалгуур хангасан

материалыг дахин хянаж үзэхэд ямар нэгэн зөрчил илэрсэнгүй. Тендерийг шалгаруулахдаа ТБОНӨХБАҮХАТХ-г тухай хуулийг мөрдөж ажилласан байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 16 ажилд худалдан авах ажиллагааг зохион байгуулахад 5 нээлттэй, 11 харицуулалтын аргаар зохион байгуулсан байна. Үүнд давхардсан тоогоор орон нутгийн 10 аж ахуй нэгж байгууллага, Улаанбаатарын харьяаны 3 аж ахуй нэгж байгууллага шалгарсан байна.

Аймгийн худалдан авах ажиллагааны албаар орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 3,755.5 сая төгрөгийн өртөгтэй 16 ажлын тендер шалгаруулалт хийж, 3,704.2 сая төгрөгийн гэрээг байгуулан 51.3 сая төгрөгийн төсвийн хэмнэлт гаргаж ажиллажээ.

В. Орон нутгийн хөрөнгө оруулалтын хийгдсэн хөрөнгийг НББ-д тусгаагүй, хүйтний улирал эхэлсэн байхад замын засварын ажлын гэрээ байгуулж 152.9 сая төгрөгөөр санхжүүлсэн хэдий одоо болтол ажил нь хийгдээгүй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн ажлуудын гэрээг шалгаж үзэхэд өмнөх онд байгууласан Хөхморьт, Жаргалан, Төгрөг сумын багийн төвийн барилгын гэрээг эс тооцвол 2015 онд ТБОНӨБАҮХАТХ-ын 40.3.Худалдан авах гэрээнд энэ хуулийн 40.2-т зааснаас гадна дараахь нөхцөлийг заавал тусгана гэж заасны дагуу гэрээнд тусгагдах ерөнхий болон тусгай нөхцлийг бүрэн тусгаж өгч гэрээг байгууласан байна. Өмнөх оны аудитаар гэрээний заалтыг нэг болгох талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласанаар зөрчлийг давтан гаргаагүй байна.

Тайлант онд санхүүжүүлсэн аймгийн төвийн авто замын засварын нөхөөсний 5 ажлыг гэрээг 2015 оны 10 дугаар сарын 13-наас 2015 оны 11 дүгээр сарын 13-ний хооронд хийж гүйцэтгэхээр гэрээ байгуулж 152.9 сая төгрөгийн санхүүжилт буюу 81.3 хувийг олгосон байна. Гэвч 2015 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр цаг агаарын байдлаас гүйцэтгэх боломжгүй байгаа тул гэрээг сунгасан байна.

Гэрээ байгуулласан өдрөөс хойш нөхөөс хийх замыг прейз татсанаар өөр ажил хийгдээгүй ГХБХБГ-аас хяналт тавиагүй байна. "Тэмүүн -Холдинг" ХХК нь тус ажлыг одоог хүртэл хийж гүйцэтгээгүй, нэмэлт гэрээ хийсэн нь хувийн компанд төсвийн мөнгийг 5 сар ашиглуулсан байна.

Зөрчсөн хуулийн заалт: ТБОНӨХБАҮХАТХ-ийн 46.1.8-ын Барилга, зам, инженерийн шугам сүлжээ зэрэг тодорхой улиралд гүйцэтгэх онцлог шинж чанартай бараа, ажил үйлчилгээг худалдан авах ажиллагааг тухайн жилийн 1 дүгээр сарын 15-ны дотор эхлүүлэх,

Тайланд онд хэрэгжсэн хөрөнгө оруулалтын 19 ажлаас 8 ажлын хугацааг сунгаж, Хүрэн голын багийн төв, Эрдэнэ сумын багийн төвүүдийн барилгын ажлууд 9-11 хоногоор хугацаа хоцорсон бөгөөд хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн нь тухай ажлын алдангийг суутган тооцсон байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 9,806.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 27 ажлыг хэрэгжүүлэхээр батлагдсанаас, 3,557.6 сая төгрөгийн гэрээний дүнтэй 14 ажил тайлант онд хэрэгжиж, өмнөх оноос шилжиж ирсэн 5,947.5 сая төгрөгийн 7 ажил, тайлант онд гүйцэтгэхээр төлөвлөсөн боловч хэрэгжээгүй 188.3 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлууд байна./ Хавсралт№6/

Тайланд онд бүрэн хэрэгжсэн ажлуудын хэрэгжилтийг авч үзэхэд дараах байдалтай байна.

Бүрэн багийн төв барих / Жаргалан/, Хүрэн голын багийн төв барих /Төгрөг/, Сангийн далай багийн төв барих /Хөхморьт/:

Аймгийн ИТХ-ын 2014 оны 07 сарын 22 өдрийн 67 дугаар тогтоолоор 3 багийн төвийн байр барих нийт 80.0 сая төгрөгийн төсөв батлагдаж харьцуулалтын аргаар тендер шалгаруулалт зарлагдаж "Орд харш" ХХК-тай шалгарсан байна.



Жаргалан сум бүрэн багийн төвийн байр

Хөхморьт сумын Сангийн Далай багийн төвийн байр



Төгрөг сумын Хүрэн багийн төвийн байр

Дээрх багийн төвийн барилгын ажлыг газар дээр нь шалгаж үзэхэд: Хөхморьт сумын Сангийн далай багийн төвийн барилга суулт өгсөн, суулт өгсөнөөс барилгын хана цуурсан цонх хагарсан байдалтай байна. Захиалагч, гүйцтгэгчийн хооронд байгуулласан гэрээнд баталгаат хугацааг зааж өгөөгүй хэдий ч барилгын тухай хуулийн дагуу эдрэлтэй хэсгийг дахин засуулах нь зүйтэй юм.

Зөрчсөн хуулийн заалт: ТБОНӨХБАҮХАТХ-ийн 40.3/.Худалдан авах гэрээнд энэ хуулийн 40.2-т зааснаас гадна дараахь нөхцөлийг заавал тусгана/-ыг зөрчсөн байна.

Хүүхдийн цэцэрлэг барих: Бигэр сумд-1,027.0 сая төгрөг, Тонхил сумд-1,032.0 сая төгрөг, Төгрөг сумд 924.6 сая төгрөгийн цэцэрлэгийн барилгуудыг аймгийн ИТХ-ын 2015 оны 03 сарын 01 ны өдрийн 02 дугаар тогтоолоор батлаж, нээлттэй тендерийн аргаар шалгаруулан барьж хүлээлгэн өгсөн байна. Ашиглалтанд хүлээлгэн өгөөд удаагүй бөгөөд Төгрөг, Тонхил сумдын тухайд ямар нэгэн эвдрэл гэмтэл гараагүй байна.

Бигэр сумын 100 хүүхдийн цэцэрлэгийн хувьд: Барилгын гадна хайс хашаа, явган хүний зам, галалгааны байрны дотор талын тохижилт, яндангийн бэхэлгээ хийх ажил, барилгын хаяавч, агаарын шат хаалга, гал тогооны уур дарагч, бүлгүүдийн шал суулт

өгсөн, хана дахин засварлах, цэвэр бохир усны шугам солих ажлуудыг хийгээгүй байхад улсын комисс хүлээн авсан нь хариуцсан ажилдаа хариуцлагагүй хандсан үйлдэл болсон байна.

Тонхил сумын Хүүхдийн цэцэрлэг

Бигэр сумын хүүхдийн цэцэрлэг

Зөрчигдсөн хуулийн заалт: 2015 оны 6 дугаар сарын 22-ний өдрийн Аймгийн Засаг даргын баталсан "Барилга их засварын ажлын гүйцэтгэгч, захиалагч хяналт гүйцэтгэгчийн хооронд байгуулсан 3-ласан гэрээ дугаар А220/10/15 Захиалагчийн эрх үүрэг үйл ажиллагаа" 2.1.1 /Зураг төсөл, техникийн даалгавараас зөрүүтэй боловсруулсан зураг төсөл, ажил болон техникийн хүчин чадал, технологийн шаардлагыг хангаагүй бүрэн бус тоног төхөөрөмж машин механизм, материалыг хүлээн авахыг татгалзах/-ыг зөрчсөн байна.

Гадна LED дэлгэц байршуулах: ИТХ-ын 2015 оны 12 сарын 04 ны өдрийн 12 дугаар тогтоолоор батлагдсан байна. Харьцуулалтын аргаар шалгаруулсан 7 компани тендерт оролцсон хэдий тендерийн баримт бичгийн хангасан материал ирүүлээгүй тул шууд гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг олгож "Алтай нуруу шонхор" ХХК-тай гэрээ байгуулан гүйцэтгүүлсэн байна.



"Гадна LED дэлгэц "

"АЗД авто гражын барилга

Урьд оны хөрөнгө оруулалтын ажлууд: Хөхморьт, Жаргалан, Төгрөг сумдын багийн төвийн байр 54.0 сая төгрөгөөр, аймгийн ЗДТГ-ын гараж үйлчилгээний барилга 38.8 сая, Баянхайрхан багийн 3.8 авто зам 774.9 сая төгрөг, Жаргалант багийн гэр хорооллын 1.8 км авто зам 570.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын ажлыг санхүүжүүлэхээр ИТХ-батлагдаж өгснөөр дээрх ажлууд бүрэн хийгдэж хүлээлгэн өгсөн байна.

Хийгдээгүй хөрөнгө оруулалтын ажлын талаар: Тайланд онд Алтай хотын Хөгжил, Харзат, Баянхайрхан хорооллын замын нөхөөс хийх, Жанчивын гудамжны явган замын ажилд 188.4 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр гэрээ байгуулан 152.9 сая төгрөгийн санхүүжилтийг авсан хэдий ч одоо болтол ажлыг гүйцэтгээгүй байна.

Зөрчсөн хуулийн заалт: ТБОНӨХБАҮХАТХ-ийн 46.1.8-ын Барилга, зам, инженерийн шугам сүлжээ зэрэг тодорхой улиралд гүйцэтгэх онцлог шинж чанартай бараа, ажил үйлчилгээг худалдан авах ажиллагааг тухайн жилийн 1 дүгээр сарын 15-ны дотор эхлүүлэх.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлыг ГХБХБГ-аас захиалагчийн хяналт хийж баталгаажуулсан эсэхийг шалгаж үзэхэд 8 ажилд захиалагчийн хяналт хийхээр гэрээ байгуулан хяналтийг хийж баталгаажуулсан бөгөөд барилгын ил, далд ажлын акт болон барилгын журналаар нотлогдож байна.

Хөрөнгө оруулалт болон их засварын хувьд ажил бүрт зохиогчийн хяналт хийгдэхгүй нэгдсэн нэг хяналтын ажил хийгдэж байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалт хийгдэж байгаа Соёл амралтын хүрээлэн 1-р багцын ажлыг гэрээнд заасан талбайн хэмжээнээс бага талбайг хашаалсан, Жаргалан сумын Бүрэн багийн төвийн барилгыг зураг төсвөөс захиалагчын хүсэлтээр өөрчилсөн хэдий ч зөвшөөрөл аваагүйгээс үзэхэд барилгын ажлыг хүлээн авах комиссын бүрэлдэхүүнд зохиогчийг заавал оруулах нь зүйтэй юм.

Зөрчсөн хуулийн заалт: Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 73 дугаар тогтоолын хавсралт барилга захиалагчийн дүрэм 3.1.7. барилгын ажлын үе шат бүрт зохиогчийн хяналтыг гүйцэтгүүлэх заалтыг зөрчсөн байна.

НББ, Шилэн дансны тухай :

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг авч үзэхэд: Тайланд онд мэдээлэх ёстой 6,175.4 мянган төгрөгөөс, 6,170.1 мянган төгрөгийг мэдээлсэн бөгөөд Эрдэнэ сумын багийн төвийн барилгын санхүүжилтийг 5.3 сая төгрөгөөр дутуу мэдээлсэн байна. 2016 оны хувьд тендерт шалгарсан аж ахуй нэгж байгууллагуудын шилэн дансанд мэдээллийг бүрэн оруулах тал дээр үр дүнтэй ажил зохион байгуулж ажиллах шаардлагатай байна.

Зөрчигдсөн хуулийн заалт: Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5 дахь заалт/Шилэн дансны нэгдсэн цахим хуудасны цэс нь энэ хуулийн 3.2-т заасан ангиллыг баримталсан байх бөгөөд мэдээллийг бүрэн тусгасан байна.3.2 дахь заалт/Энэ хуульд дараах төсөв, санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагнал эдгээртэй холбоотой мөнгөн болон бусад гүйлгээ хамаарна/ гэсэн зөрчсөн байна.

Тайлант онд хэрэгжсэн хөрөнгө оруулалтын ажлыг НББ-д тусгасан эсэхийг шалгаж үзэхэд дараах байдалтай байна.

Хүснэгт 3

№	Хөрөнгө оруулалтын нэр	Мөнгөн дүн	Орлого авах байгууллага	Хариуцах эзэн
1	Бигэр сумын Хүүхдийн цэцэрлэг	500.0	Бигэр сумын Хүүхдийн цэцэрлэг	Бигэр сумын Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч Б.Нэргүй, нягтлан бодогч Н.Отгонбаатар
2	Есөнбулаг сумын доод талын тоглоомын талбай	20.0	Есөнбулаг сумын ЗДТГ	Есөнбулаг сумын ЗДТГ-ын дарга С.Эрдэнэ. нягтлан бодогч М.Хонгорзул
3	Рашаант багийн багийн төв	29.6	Есөнбулаг сумын ЗДТГ	Есөнбулаг сумын ЗДТГ-ын дарга С.Эрдэнэ. нягтлан бодогч М.Хонгорзул
4	Андууд зуслангийн дээврийн засвар	25.0	ХГБХХ	ХГБХХ-ын нягтлан бодогч Д.Гачуу
5	Монгол банкны зүүн хойд талын авто зам	4.9	Алтай хотын тохижилт үйлчилгээний газар	Алтай хотын тохижилт үйлчилгээний газрын дарга Г.Ганбаатар, Б.Хаш-Эрдэнэ
	Нийт дүн	**579.0**		

Зөрчсөн хуулийн заалт: НББОУС, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 25 дугаар зүйл Төрийн өмчийн эд хөрөнгийг үнэлж, бүртгэх 1/Төрийн өмчийн эд хөрөнгийг НББ-ийн 7 дугаар зүйлд заасан журмаар үнэлж бүртгэнэ/-ыг зөрчсөн байна.

Өмнөх аудитын шийдвэрийн хэрэгжилт:

Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2014 онд санхүүлжүүлсэн хөрөнгө оруулалт төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн аудитаар 54.9 сая төгрөгийг акт тогтоож, 3,301.0 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгуулах болон 4 албан тушаалтанд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлсэн байна. Аудитын явцад төлбөрийн актыг бүрэн барагдууллаа. Албан шаардлага 100 хувь биелэгдсэн байна. Эндээс харахад өмнөх аудитаар өгсөн шийдвэрийг бүрэн хэрэгжүүлж өмнөх аудитаар гарч байсан зөрчлийг арилгасан байна

"Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2014 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээниий хэрэгжилт, үр дүн" гүйцэтгэлийн аудитын шийдвэрийн хэрэгжилтийг хүснэгтээр харуулвал:

Хүснэгт:4 /сая.төг/

Д Д	Сум, байгууллагын нэр	Өгөгдсөн			Хэрэгжүүлсэн			Хэрэгжүүлээгүй		
		Төлбөрийн акт	Албан шаардлага	хариуцлага тооцох	Төлбөрийн акт	Албан шаардлага	хариуцлага тооцох	Төлбөрийн акт	Албан шаардлага	хариуцлага тооцох
1	Дэлгэр сумын засаг дарга		2.0			2.0		0.0	0.0	0.0
2	Мандал голомт ХХК	54.9			54.9			0.0	0.0	0.0
3	Аймгийн засаг дарга		164.1	1.0		164.1	1.0	0.0	0.0	0.0
4	ХАА-ын алба							0.0	0.0	0.0
5	Үйлдвэр хөдөө аж ахуйн газар		113.7			113.7		0.0	0.0	0.0
6	Цогт сум ЗДТГ, "АУЭХС" ГӨХК, МСҮТ		2,979.4			2,979.4		0.0	0.0	0.0
7	Хөгжлийн бодлогын хэлтэс		41.8			41.8		0.0	0.0	0.0
8	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын алба			3.0			3.0	0.0	0.0	0.0
	НИЙТ ДҮН	54.9	3,301.0	4.0	54.9	3,301.0	4.0	0.0	0.0	0.0

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын илрүүлэлт:

1. Шилэн дансны цахим хуудсанд Орон нутгийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг 2015 онд 5.3 сая төгрөгөөр дутуу байршуулсан байна.
2. Аймгийн авто замын сангийн хөрөнгөөр аймгийн хэмжээнд хийгдэх зам засварын нөхөөс ажлыг хийлгэхээр "Тэмүүн-Холдинг" ХХК-д гэрээ байгуулан 152.9 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. "Тэмүүн -Холдинг" ХХК нь тус ажлыг одоог хүртэл хийж гүйцэтгээгүй, нэмэлт гэрээ хийсэн нь хувийн компанд төсвийн мөнгийг 5 сар ашиглуулсан байна.
3. Бигэр сумын Хүүхдийн цэцэрлэгийн барилга 500.0 сая төгрөг, Есөнбулаг сумын ЗДТГ-ын доод талын тоглоомын талбай-20.0 сая төгрөг, Рашаант багийн барилга 29.7 сая төгрөг, андууд зуслангийн дээврийн засвар 25.0 сая төгрөг, Монгол банкны зүүн хойд талын авто зам 4.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг НББ-д орлого аваагүй байна.
4. Орон нутгийн төсвийн хөөрнгөөр оруулалтаар 2015 онд хийгдсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэлд зохиогчийн хяналт огт тавиагүй, Улсын

төсвийн хөрөнгө оруулалт хийгдэж байгаа Соёл амралтын хүрээлэн 1-р багцын ажлыг гэрээнд заасан талбайн хэмжээнээс бага талбайг хашаалсан, Жаргалан сумын Бүрэн багийн төвийн барилгыг зураг төсвөөс захиалагчын хүсэлтээр өөрчилсөн хэдий ч зөвшөөрөл аваагүйгээс үзэхэд барилгын ажлыг хүлээн авах комиссын бүрэлдэхүүнд зохиогчийг заавал оруулах нь зүйтэй юм.

5. Баян-Шанд багийн Эрчмийн дээд уулзварын замыг "Ундрага Алтай" ХХК сэтлэж шугам сүлжээ гаргасан хэдий эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл аваагүй байна.

III Бүлэг. Төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр Хөгжлийн банкнаас 2015 онд санхүүжсэн төсөл,арга хэмжээний үр дүн
Говь-Алтай аймагт Хөгжлийн банкнаас 2015 онд эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр зээл олгоогүй байна.

Албан шаардлага

1. **Аймгийн засаг дарга О.Амгаланбаатарт**
   - Хийх ажлын онцлогоос шалтгаалан худалдан авах ажиллагаа явуулах, гэрээ байгуулах, ажил гүйцэтгэх хугацааг оны эхнээс төлөвлөж зохион байгуулах
2. **Есөнбулаг сумын Засаг дарга М.Дашпунцагт**
   - Аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан "Алтай хотын замыг сэтлэх, орц гарц гаргах болон зогсоолын талбай хийх, зөвшөөрөл олгох журмыг хэрэгжүүлэн, хэрэгжилтэд хяналт тавьж, хариуцлага тооцож ажиллах
3. **Хөгжлийн бодлогын хэлтэс**
   - Ажлын явц хангалтгүй байгаа соёл амралтын хүрээлэн байгуулах ажлыг эрчимжүүлэн үе шатны хяналтыг тавьж үр дүнг тооцож ажиллах
   - Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангуулан ажилла

4. Орон нутгийн өмчийн албаны дарга Л.Ганхуяг танаа

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийсэн ажлын үр дүнд бий болсон хөрөнгүүдийг харьяалах байгууллагын нягтлан бодох бүртгэлд бүртгүүлэн, тайлагнуулж байх.

5. Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ч.Чинзориг танаа

- Ажлын явц хангалтгүй байгаа соёл амралтын хүрээлэн байгуулах ажлыг эрчимжүүлэн үе шатнйы хяналтыг тухай бүр нь тавьж ажилла.
- Үе шатны ажлуудад зохиогчийн хяналтыг тавьж баталгаажуулж талаар гэрээнд тусгаж, хяналтыг сайжруулах талаар тодорхой ажил зохион байгуулах

Үндэсний аудитын газарт хүргүүлэх санал

Үндэсний аудитын газрын харьяа Гүйцэтгэлийн аудитын газарт :

Улсын төсвийн хөрөнгөөр 2015 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитаар дараахь зөрчил илэрч байна. Үүнд:

1. УТХО-аар 2008-2015 онуудад хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтын ажлуудаас аймгийн хэмжээнд нийт 16 ажлын гүйцэтгэл 30-70 хувьтай явагдаж байна. Үүнээс Хот суурин газрын захиргаа, сав газрын захиргаа байгуулах ажил, аймаг, сум суурин нутаг дэвсгэрт газар хөдлөлийн бичил, мужлалын зураглал хийх, газар хөдлөлийн эрсдлийг тодорхойлоход чиглэсэн инженер, геологи, гидрогеологи, газар хөдлөл техникийн судалгааны ажил огт хийгдээгүй байна.

2. УТХО-аар 2008-2015 онуудад хэрэгжиж байгаа хөрөнгө оруулалтын ажлуудын гүйцэтгэлд хяналт тавьж санхүүжүүлэхгүй байгаагаас он дамжин удааширч төсөвт өртөг нь анх баталсан дүнгээс 3,667.9 сая төгрөгөөр нэмэгдэн батлагдсан байна. Мөн Хүүхдийн ордны барилгын цонх хагарсан, хажуу хана руу ус орсон зэргээр чанар байдалд нь сөрөг нөлөө гарсаар байна

ҮАГ-ын гүйцэтгэлийн газарт хүргүүлэх санал:

1. Аймгийн хэмжээнд дутуу болон огт хэрэгжээгүй байгаа хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээний талаар нэгдсэн тайлангаар холбогдох байгууллагад уламжлаж шийдвэрлэж өгнө үү.

ДАРГА , ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР **Х.ТҮВШИНБАЯР**

9. Түлшний зардлыг гэрт үйл ажиллагаа явуулж байгаа санал авах байранд түлшинд зарцуулах
10. Сумын сонгуулийн хорооны гишүүний урамшуулал 1 хүн – 230400
11. Санал авах байрны ахлах зохин байгуулагчийн урамшуулал 1 хүн-211200
12. Санал авах байрны зохин байгуулагчийн урамшуулал 1 хүн -192000
13. Сонгуулийн байгууллагын ажилтны хоолны зардал 1 хүн -50000, сонгуулийн хороонд -200000
14. Санал авах байрны даамлын урамшуулал 1 хүн- 230400, хоолны мөнгө 1 хүн 30000 төгрөг байх
15. Сумын сонгуулийн хорооны дансанд гүйлгээ хийх хөтөлбөрийн код 70403, зориулалт 81503, эдийн засгийн ангилал 210901 кодоор гүйлгээ хийнэ.

Сумын сонгуулийн хорооны дарга нар сумын сонгуулийн хорооны гишүүд, санал авах байрны ахлах зохион байгуулагч, зохион байгуулагч нарын урамшуулал, хоолны зардлын тухай захирамжийг хүн тус бүрийн нэрээр гаргаж хувь хүмүүсийн цалингийн болон холбогдох данс руу нь шилжүүлнэ.Урамшуулал, хоолны зардлыг өөр зориулалтаар зарцуулах, захирамжинд дурдагдаагүй хүнд олгож болохгүй бөгөөд урамшуулал хоолны зардлаас ХХОАТ-ыг суутгаж олгохыг анхаарна уу.

МТ-ын даамал МТБ-аас иж бүрэн техник хэрэгслийг хүлээлгэн өгөх унаа, томилолтын зардлыг ирж очих шатахууны зардал, томилолтыг 3 даамал /3*29000*2 хоног/ жолооч 1*14000*2 хоног байхаар тооцов.

Сонгуулийн хорооны зардлыг дахин хуваарилахгүй бөгөөд санхүүгийн анхан шатны баримтыг сайн бүрдүүлж, зардлыг зориулалтын дагуу зарцуулж ажиллахыг хүсье.

ДАРГА А. МӨНХТӨР